

Эрт үед Галилын нутаг дэвсгэрт байдаг Кана хэмээх тосгонд хуримын найр болж байлаа.

Тэр хуриманд Есүс болон Түүний шавь нар мөн эх Мариагийн хамтаар уригдсан байлаа.

Хуриманд уригдсан зочид нь амтат хоолоор дайлуулж, ууцгаан хөгжилтэй цагийг өнгөрөөж байв.

Бүгд цагийг сайхан өнгөрөөж байх яг тэр үед! Гэнэт нэгэн зарц яаран гүйж ирээд найрын ахлагчид ингэж хэлэв.

“Бидэнд асуудал үүслээ! Усан үзмийн дарс бүгд дуусчихлаа! Бидний бодсоноос ч илүү их зочид хүрэлцэн ирсэн бололтой. Одоо бидэнд дусал ч дарс үлдсэнгүй.” гэв. Найрын ахлагч яах учраа олохгүй байх үед Есүсийн эх Мариа усан үзмийн дарс дууссан гэх мэдээг сонсов. Тэгээд Мариа Есүсийг хайж эхлэв.

Учир нь Мариа, энэ асуудалд Есүс тусалж чадна гэдэгт итгэж байв. Тиймээс ч Мариа зарц нарт “Есүсийн айлдсаны дагуу хийгээрэй” гэж хэлэв. Есүс болон зарц нар хамтдаа хуримын найр болж байгаа газарруу ойртон очив.

Тэнд чулуун торх зургаан ширхэг байлаа.

Тэр чулуун торхнуудыг юунд ашигладаг байсан бэ гэвэл гадагшаа гараад буцаад ирэхдээ гараа угаах ус юм уу эсвэл аяга тавгаа угаах усыг хадгалдаг савнууд байлаа.

Есүс зарц нарт ингэж айлдав. “Торхнуудыг усаар дүүргэ” гэв. Зарц нар Түүний хэлсний учрыг ерөөсөө ойлгохгүй байв.

Гэхдээ Есүсийн айлдсанчлан торхнуудыг усаар дүүргэж эхлэв.

Харин зарц нар найрын ахлагчид усан үзмийн дарс аваачиж өгөв.

Зарц нарын авчирсан усан үзмийн дарсыг найрын ахлагч амсах мөчид түүний царай баясалтай болов.

Тэр усан үзмийн дарсыг хаанаас бий болсныг мэдэхгүй ч сэтгэл нь хөөрч сүйт залууруу яаравчлав.

Тэгээд тэрээр ингэж хэлэв.

“Аливаа хүн эхлээд сайн дарсаа гаргаад, хүмүүсийг согтсоны дараа муухнаа гаргадаг.

Гэтэл чи эхэнд ч тэр төгсгөлд ч тэр сайн дарсаа гаргаж өгч байна. Үнэхээр гайхалтай.”


Тэр өдөр хуримын найранд ирсэн бүх зочид Есүсийн усаар хийсэн хамгийн сайн дарсыг ууж, хуримын найр дуустал цагийг сайхан өнгөрүүлэв.



Доорх зургийг өнгөөр ялган будаж хайчилбарын дагуу хайчлаарай. Цаас тогтоогчыг улаан, цэнхэр өнгөөр ялган будсан дугуй дүрсийн гол хэсэгт байгаа хар цэг дээр байрлуулан, жишээ зураг шиг хийгээрэй. Ваарнаас ус болон усан үзмийн дарс гарч ирнэ.



Материал:
Хайч, Өнгийн харандаа, Цаас тогтоогч



Бүтээлч байцгаая 2.

Эхний асуултын хариултыг олохын тулд 1 гэсэн тоотой үсгүүдийг цуглуулж, үсэгнүүдийг зөв байрлалд оруулж хариултыг олоорой. Үлдсэн асуултуудад ч бас яг адилхан маягаар олж хариулаарай.

3	2	1	3	4	1	3
А	С	А	С	Г	А	Н
4	1	3	4	3	5	4
Э	Н	А	Н	Я	Э	Т
3	4	3	5	2	3	5
Б	С	Л	Ф	У	Г	Х
3	3	3	1	4	3	4
Й	А	А	К	Э	Т	И

1. Хуримын найр хаана болж байсан бэ? (1)

2. Зарц нар 6 ширхэг чулуун торхыг юугаар дүүргэсэн бэ?

3. Усаар хийсэн дарсыг амталсан найрын ахлагч ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?

4. Иохан 2:1-12 эшлэлийг уншаад хариулаарай.

Усыг дарс болгон өөрчлөн гайхамшгийг үйлдсэн Есүсийг харсан шавь нар ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Иохан 2:5)

“Эх нь үйлчлэгчдэд – Тэр та нарт юу айлдана, түүнийг үйлд гэв.”